

**МОНГОЛЫН УСАН СПОРТ
СОНИРХОГЧДЫН ХОЛБОО**



**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН
2010 - 2016**



2016 он



АГУУЛГА

Бүлэг 1

Удирдлага

Бүлэг 2

2010 оны тайлан

Бүлэг 3

2011 оны тайлан

Бүлэг 4

2012 оны тайлан

Бүлэг 5

2013 оны тайлан

Бүлэг 6

2014 оны тайлан

Бүлэг 7

2015 оны тайлан

Бүлэг 8

2016 оны тайлан

Бүлэг 9

Сургалт, зохион байгуулалт



Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо (2016)

Эмхэтгэсэн: Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын алба

Цаасны хэмжээ: 210x275

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо ширхэг:

Улаанбаатар хот 2016

МЭНДЧИЛГЭЭ

МУССХолбоо нь 2010-2016 онд хийсэн ажлаа Та бүхэнд өргөн барьж байна.



Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛӨГЧ

**ЧИЛТЭМИЙН
УЛААН**



Тайлангийн хугацаанд 2010 онд хуралдсан тэргүүлэгчдийн хурлаар дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэх болон өөрийн дүрэм, Олон улсын усан спортын дүрмийн дагуу хүлээсэн үүргүүдээ амжилттай хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллав.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Олон улсын усан спортын холбооны ивээл дор зохиогдсон Дубай-2010, Шанхай-2011, Истанбул-2012, Барселон-2013, Доха-2014, Казан-2015 дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Лима-2011, Сингапур-2015 залуучуудын ДАШТ, ОУОХ-ны ивээл дор зохиогдсон Лондон-2012 зуны олимпийн наадам, Сингапур-2010 залуучуудын олимпийн наадам, Азийн тулааны спортын наадам, Азийн заалны наадам, Азийн хүүхдийн спортын наадмуудад тамирчдаа амжилттай зохион байгуулж оролцууллаа.

Олон улсын холбооны сургалтын хороонд Монгол улсдаа сургалтыг зохион явуулах эрх авах талаар 4 жил нэр дэвшиж 2015 онд Олон улсын усан спортын холбооны хурлын шийдвэрээр эх орондоо зохион явуулах эрхийг авч 2016 онд амжилттай зохион байгуулж олон улсын усан спортын холбооноос өндөр үнэлэлт авлаа.

Дэвшүүлсэн зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхэд бидэнтэй хамтран ажилласан спорт, усан спортын их гэр бүлийн гишүүд, ивээн тэтгэгчиддээ гүн талархалаа илэрхийлье.



Удирдлага

Бүлэг 1

Бидний тухай

Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо /МУССХ/ Монгол улсад усан спортыг хөгжүүлэх үндсэн зорилготой нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаар 1991 оноос үйл ажиллагаагаа явуулсаар байна.

МУССХолбоо нь усан спортыг сурталчилж, хичээллэгсэдийн эгнээг өргөжүүлэх, усан спортын материаллаг бааз, боловсон хүчний хангамж, бэлтгэл сургалтыг сайжруулах, өндөр ур чадвартай тамирчид бэлтгэхийг зохион байгуулах замаар үндсэн зорилгоо хэрэгжүүлж байгаа ба Олимпийн хөдөлгөөнийг дэмжиж, гадаадын олон улс орнуудын усан спортын холбоодтой хамтын ажиллагааны идэвхтэй үйл ажиллагаа явуулж, тэдний дэмжлэг тусалцааг авч байна.





Анх 1969 оноос Туул голын эрэгт усны гольдрол ашиглан 50 метрийн задгай усан бассейн байгуулан улс, хотын аваргын тэмцээнийг жил бүр зохион байгуулж ирснээс гадна хүүхэд залуучуудыг усан спортоор хичээллүүлж иргэдийг усанд сэлж сургах ажлыг зохион байгуулж ирснээр монголд анх усан спортын хөгжил суурь тавигдсан.

Манай улсад 1984 онд Эрдэнэт хотод “Эрдэнэт үйлдвэр” ХХК-н Спорт цогцолборт 25 метрийн усан бассейн, 1986 онд Улаанбаатар хотод Хүүхэд залуучуудын усан спорт сургалтын төвийн 25 метрийн усан бассейн байгуулагдсанаар хүүхэд залуучуудын дунд усан спорт хурдацтай хөгжиж ирсэн.

МУССХ нь 1991 онд байгуулагдсанаас хойш усанд сэлэлтийн идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээн, хотын аварга шалгаруулах тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээн зохиогдох болсон.

МУССХ нь 1996 онд Олон улсын усан спортын холбоонд (FINA), 2000 онд Азийн усан спорт сонирхогчдын холбоонд (AASF) элссэн бөгөөд түүнээс хойш олон улсын тэмцээнд оролцож эхэлсэн.

Олон улсын олимпийн хороо эв нэгдэл хэмээх олимпизмийн үнэт зарчмыг эрхэмлэн дээдэлж, өөрийн гишүүн 208 улсыг олимпийн наадамд бүрэн оролцуулах зорилготой билээ.

Гэвч тогтоосон шалгуурыг давж, эрх авч чадахгүй болон тухайн төрөлд өндөр амжилт үзүүлдэггүй улсын тамирчдад урилга олгож, олимпийн наадамд оролцох боломжоор хангадаг юм.

Энэ зарчмын дагуу ОУОХ, Олон улсын усан спортын холбоо (FINA), МҮОХ, МУССХ-ноос олимпийн тоглолтонд 1 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчнаа Сидней-2000, Афин-2004, Бээжин-2008, Лондон-2012 оролцуулсан.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Анхны Ерөнхийлөгчөөр Т.Оюунгэрэл

1996-2000 онд Т.Эрдэнэбилэг УИХ-н гишүүн асан

2000-2001 онд Д.Бат-Эрдэнэ усанд сэлэлтийн дасгалжуулагч

2001 оноос одоог хүртэл УИХ-н гишүүн Ч.Улаан ажиллаж байна.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- Ерөнхийлөгч Ч.Улаан-УИХ-н гишүүн
- Дэд Ерөнхийлөгч Д.Баясгалан- Гавъяат дасгалжуулагч
- Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Энхмандах - Усан спортын дэд мастер

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН

- Г.Занданшатар – УИХ-н гишүүн, Шадар сайд
- Ж.Энхбаяр-УИХ-н гишүүн
- Р.Бадрах- Хүрээ дэл ХХК-н захирал
- Ж.Од- MCS Холдинг ХХК-н захирал
- Ш.Даваахүү – Эрдэнэт үйлдвэр ХХК-н Спорт цогцолборын захирал
- Цолмонгэрэл- УССТөвийн захирал
- О.Эрдэнэтуяа –Эрдэнэт үйлдвэр ХХК Байгаль орчны дарга
- Ж.Баасанханд-Алт импекс ХХК-н захирал
- Г.Баясгалан- Усан спортын дэд мастер
- Н.Наранбат - Усан спортын мастер
- Т.Энхцацар-Либра Консейлс Монгол ХХК-н Ерөнхий менежер
- Г.Гансүх-ЖЖ группийн захирал
- Х.Дамдинсүрэн – Sound of Mongolia ХХК-ийн захирал

МУССХолбооны Багш дасгалжуулагчдын зөвлөл нь 2010 онд 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

- Зөвлөлийн дарга С.Алтантуяа - Хангарьд спорт клубын усан бассейны ахлах дасгалжуулагч

ГИШҮҮД

- Н.Баярсайхан-Баянгол дүүргийн УССТ-ийн багш
- А.Тамир-Веста клубын багш
- Б.Энхболд-Тэмүүлэн клубын багш
- Б.Сүхбат-Плеханов сургуулийн багш
- У.Болдбаатар-Хангарьд клубын багш
- Х.Батболд- Сонгино хайрхан дүүргийн УССТ-ийн багш



2010 оны үйл ажиллагааны тайлан

Бүлэг 2



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2010 оны 10-р сард тэргүүлэгчдийн хурлаар 2010-2014 оны ажлын төлөвлөгөөг баталсан.

11-р сард багш дасгалжуулагчдын зөвлөлийн хурлыг хийж дасгалжуулагчдын зөвлөлийн гишүүдийг сонгож, 2011 онд зохион явагдах уралдаан тэмцээн болон бусад арга хэмжээний талаар хэлэлцсэн. Олон улсын спортын холбооноос анх удаа зөвлөгөөнд оролцсон. Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн амжилттай зохион явуулсан.

Дэлхийн аваргад ерөнхийлөгч Ч.Улаан, тэргүүлэгч гишүүн Т.Энхцацар, ерөнхий нарын бичгийн дарга Х.Энхмандах нарын хамт оролцож олон улсын усан спортын холбоо (FINA) -н удирдлагатай уулзалт хийж Монгол орны усан спортын хөгжлын талаар санал бодол солилцлоо.

БИ БАЙГУУЛЛАГЫНХАА НЭГЭН ХЭСЭГ

СУРГАЛТ



Сургалт дасгалжуулалт

Холбооноос нийт дасгалжуулагчдын дунд “Би байгууллагынхаа нэгэн хэсэг” сургалтыг “Өөрчлөлтийг чиглүүлэгч” сургалтын төвийг багш нартай сургалт зохион байгуулж, амжилттай болж өндөрлөсөн. Сургалтанд УССТ, Хангарьд клуб, Орчлон клуб, Виста клубүүдийн багш дасгалжуулагчид хамрагдсан.



Хамтын ажиллагаа

1. Идэрчүүд, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион явууллаа.
2. Биеийн тамир, спортын газар, дүүрэг, хөрөнгө оруулалтын газартай хамтран Улаанбаатар хотод шинээр дүүргүүдийн усан бассейны баригдах судалгааны хүрээнд Хятад улсын усан спортын холбоотой хамтран судалгаа хийсэн.
3. Өөрчлөлтийг чиглүүлэгч сургалтын төвтэй хамтарч “Би байгууллагынхаа нэгэн хэсэг” сургалтыг зохион байгуулсан
4. Дэлхийн аваргад оролцох баг тамирчдын хувцасыг Ли-нинг брендийн спортын хэрэглэлээр хангасан.

Гадаад харилцаа

Дэлхийн аварга болон тив дэлхий олон улсын уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдын материал болон холбогдох элчин сайдын яаманд виз мэдүүлэн 100 хувь тамирчид болон албаны хүмүүсийг уралдаан тэмцээнд оролцох бололцоог хангасан.

Олон улсын усан сэлэлтийн холбооны хуралд оролцсон, дэлхийн аваргад 3 тамирчин 4 албаны хүн оролцсон.






Санхүүжилт

МУССХолбооны болон FINA олон улсын холбооноос зохион явуулсан арга хэмжээнд доорх клуб, байгууллага ивээн тэтгэж үйл ажиллагаанд оролцсон.

Үүнд:

Гарсан зардлын жагсаалт:

1. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 7.700.000 төгрөг, 4410 ам.доллар
2. Залуучуудын анхдугаар олимпийн наадам - улсын төсөвөөс
3. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1.500.000 төгрөг.
4. Дасгалжуулагчдын сургалт 650.000 төгрөг





2011 оны үйл ажиллагааны тайлан

Бүлэг 3

Ерөнхий мэдээлэл


2011 оны ажлын төлөвлөгөөнд туссан улсын аварга, өсвөр үеийн, идэрчүүдийн аварга шалгаргуулах тэмцээнүүдийг зохион явуулж ирсэн.

Энэ жилийн хувьд өсвөр үе, идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 6 клубын 120 орчин тамирчин 2 өдрийн турш өрсөлдсөн. Энэ тэмцээн өмнөх тэмцээнүүдээс давуу тал нь Улаанбаатар, Эрдэнэт хотын тамирчдаас гадна Дорноговь, Сэлэнгэ аймгийн Мандал сумаас тамирчид оролцсон хамгийн олон өрсөлдөгчтэй тэмцээн болсон ба ХААН хүнс ХХК ивээн тэтгэж бидний ажилд хамтран ажилласан.

Мөн усан спортыг хөгжүүлэх үүднээс анх удаа “Энгүй тал” ХХК өөрийн нэрэмжит “Энгүй тал цом”-ын тэмцээнийг 10 сая төгрөгийн шагналын сантайгаар Эрдэнэт хотын усан бассейнд зохион байгуулж, 6 клубын 100 орчим тамирчин оролцсон. Тус тэмцээн дууссаны дараагаар “Энгүй тал” ХХК-ийн ерөнхий захирал С.Энхтайван санаачлага гарган МУССХолбооны үйл ажиллагааг дэмжин “Энгүй тал цом”-ын нэрэмжит тэмцээнийг 5 жил ивээн тэтгэж, зохион байгуулж байхаар хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

Сургалт дасгалжуулалт

Жил бүр зохион явагддаг FINA-гийн шүүгч, дасгалжуулагчийн сургалтанд анх удаа МУССХолбоо 5 шүүгч, дасгалжуулагчийг хамруулсан. Уг сургалтанд УССТ-1, Американ сургууль-1, Хангарьд клубээс 3 дасгалжуулагч нарыг явуулж олон улсын уралдаан тэмцээн шүүх эрхийг олж авсан.



Гадаад харилцаа

Олон улсын усан сэлэлтийн холбооны хуралд оролцсон.

14 дэх дэлхийн аваргад 3 тамирчин 2 албаны хүн.

Залуучуудын дэлхийн аваргад 5 тамирчин 2 албаны хүн.

Оюутаны их наадамд 5 тамирчин, 1 албаны хүн

Японы нээлттэй аварга шалгаруулах тэмцээнд 2 тамирчин 1 албаны хүн тус тус амжилттай оролцуулсан.

2012 оны Лондонгийн Олимпийн наадамд Шанхай улсад болсон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд FINA point-оор өндөр оноо авсан 1 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин оролцох эрх авсан.

FINA-гийн дасгалжуулагч шүүгчийн сургалтанд оролцуулснаар FINA олон улсын холбооноос МУССХолбоонд талархалын захидал ирсэн.



Хамтын ажиллагаа

1. “ХААН хүнс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, УССТөвтэй хамтран зохион байгуулсан өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээний мөнгөн шагналд нийт 2.500.000 төгрөгний зардлыг санхүүжүүлэн тэмцээнийг амжилттай зохион явуулсан.

2. Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион явуулсан.

3. “Энгүй тал” ХХК-тай 2011 оны 6-р сараас эхлэн 5 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулснаар жил бүр 10 сая төгрөгний шагналын сан бүхий Энгүй тал цомын төлөөх тэмцээнийг зохион байгуулахаар болсон.

4. “Кайзен Монголиа” ХХК-тай гэрээ байгуулан МУССХолбоо вэб сайтыг хийж гүйцэтгэхэд МҮОХорооны холбоодыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр холбоо вэб сайттай болсон.

5. Хангарьд спорт клуб, УССТөв тус тусдаа Улан-Үд хотын клубуудтэй хамтран ажиллаж, нөхөрсөг тэмцээнд амжилттай оролцсон.

6. Дэлхийн аварга, залуучуудын дэлхийн аваргад оролцох баг тамирчдын хамтарсан бэлтгэлийн хүрээнд Биеийн тамир спортын газрын дэргэдэх Олимпийн баазад 14 хоногийн хугацаанд анх удаа 20 гаруй тамирчдыг хамруулан бэлтгэл сургуулалт хийсэн.



Санхүүжилт

МУССХолбооны болон FINA олон улсын холбооноос зохион явуулсан арга хэмжээнд доорх клуб, байгууллага ивээн тэтгэж үйл ажиллагаанд оролцсон.

Үүнд:

Гарсан зардлын жагсаалт:

Хангарьд клубээс нийт 51000 ам.доллар, 3 сая төгрөг.

1. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 4500 ам.доллар
2. Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 45000 ам.доллар

3. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 000 000 төгрөг

4. FINA дасгалжуулагчийн сургалтанд 1500 ам.доллар

MCS группээс нийт 1900 ам.доллар, 2 962 500 төгрөг.

1. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 1900 ам.доллар

2. Оюутаны их наадамд 2 962 500 төгрөг

УССТөвөөс 1500 ам.доллар.

1. FINA дасгалжуулагчийн сургалтанд 1500 ам.доллар

ХААН хүнс ХХК-аас 2011 онд 2 500 000 төгрөг.

1. Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд

Энгүй тал ХХК өөрийн нэрэмжит тэмцээнд 10 сая төгрөг.


1. Энгүй тал сур анхдугаар усан сэлэлтийн тэмцээнд

БТСГазраас 2011 онд дэлхийн аваргын цугларалтын байр, хоолны зардлыг гаргасан болно.

Хятад улсын Лининг брендийн спортын хувцас болон хэрэглэлд 1'650'000 төгрөгний зардал гаргасан. Энэ жил байгууллага, хувь хүний нийт санхүүжилт 60'000 ам.доллар, 20'112'500 төгрөгийг бэлтгэл цугларалт, гадаад, дотоодын уралдаан тэмцээнд зарцуулсан байна.

МҮОХ-ноос хэрэгжүүлж буй спортын холбоодыг дэмжих хөтөлбөрийн дагуу эхний ээлжинд 1'800'000 төгрөгний санхүүжилтээр холбооны

<http://www.masf.mn> веб сайтыг хийж олны хүртээл болгосон.



Хэвлэл мэдээлэл

Өсвөр үе, идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд ивээн тэтгэгч байгууллагыг сурталчилах самбар хийлгэж усан бассейныг тойруулан тавьсанаар олон улсын уралдаан тэмцээн явуулах хэмжээнд очсон.

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Орхон аймагт зохион явуулаж орон нутгийн телевиз болон хэвлэлээр цацагдсан.

Дэлхийн аваргад оролцох баг тамирчдын бэлтгэлийн хувцас өгөх ёслолын арга хэмжээг Ерөнхийлөгч Ч.Улаан болон МҮОХ ны Дэд ерөнхийлөгч Ц.Дамдин нар гардуулан өгч вэб сайт болон сонинд хэвлэгдэв.

Холбооны вэб сайтыг МҮОХ-ноос хэрэгжүүлж буй спортын холбоодыг дэмжих хөтөлбөрийн дагуу холбооны веб сайтыг шинээр хийж холбооны мэдээ мэдээлэлийг, холбооны үйл ажиллагаа, гадаад, дотоод уралдаан тэмцээнд хэрхэн оролцсон ямар амжилт гаргасан, дотоодод болон гадаадад болсон усан сэлэлтийн спортын зарим онцлох үйл явдлыг тухай мэдээллийн сайтанд байнга оруулж идэвхитэй болгосон.

Биеийн тамир, спортын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд спортын байгууллагууд өөрсдийгөө олон нийтэд сурталчилах 3 өдрийн үзэсгэлэнд идэвхитэй оролцон хэвлэл мэдээлэлд мэдээ өгсөн. Энэ үеэр холбооны анхны тохимол гарган олон нийтэд тараасан.

FINA-гийн дүрмийг орчуулан товхимол гаргахад бэлэн болгосон.



Шагнал урамшуулал

Насанд хүрэгчдийн улсын аврага шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан спортын мастерийн болзол хангасан Хангарьд клубын тамирчин Б.Дөлгөөн, спортын дэд мастерийн болзол хангасан Хангарьд клубын тамирчин Г.Уртнасан, Э.Дэмүүл, Б.Болдбаатар нарыг тэргүүлэгч гишүүн О.Эрдэнэтуяа хувиасаа мөнгөн шагнал гардуулан өгч тамирчдыг урамшууллаа.

Спортод оруулсан хувь нэмэрийг үнэлж МҮОХорооны дээд шагнал “Олимпийн алдар” одонгоор Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Энхмандах шагнагдсан.

Цол зэрэг

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын цол зэргийг биелүүлсэн тамирчид:

Спортын мастер

Б.Дөлгөөн 100м далайн гахай сэлэлтээр

Спортын дэд мастер

1. Г.Уртнасан 100м мэлхий сэлэлтээр
2. Э.Дэмүүл 100м араар даллах сэлэлтээр
3. М.Болдбаатар 100м мэлхий сэлэлтээр





**Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах
тэмцээн, Перу улс Лима хот**



**Шүүгчийн албан ёсны сургалт
Хонг Конг улс**





Шинэ жил 2011

Шилдэг эрэгтэй тамирчин - Б.Дөлгөөн


Шилдэг эмэгтэй тамирчин - Э.Сүрэнням

Шилдэг дасгалжуулагч - С.Алтантуяа



*Биеийн тамир спортын 90 жилийн ойн
хүрээнд үзэсгэлэнд оролцов.*







2012 оны үйл ажиллагааны тайлан

Бүлэг 4

Ерөнхий мэдээлэл

Монголын усан спортын холбоо 2012 онд багш дасгалжуулагчдын зөвлөлийн хурлыг 1-р сард хийж 2012 онд зохион явагдах уралдаан тэмцээн болон бусад арга хэмжээг тэргүүлэгчдийн хурлаар оруулан баталуулсан.


Олон улсын усны холбооны дүрмийн дагуу задгай усанд сэлэлтийн төрлөөр эрэгтэйчүүд 5км, эмэгтэйчүүд 3км зайд Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн цагаан нуурт анх удаа амжилттай зохион явуулсан.


Сингапур улсад зохиогдсон 3 дах Сингапур улсын аварга шалгаруулах тэмцээнд анх удаа өсвөр үе, идэрчүүдийн тамирчид амжилттай оролцсон.

Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Биеийн тамир спортын газраас 2011 оны үйл ажиллагаагаараа манай холбоо шилдэг холбоогоор шалгарч үйл ажиллагааны зардал, мөнгөн шагналаар шагнуулсан.

Олон улсын усан сэлэлтийн холбоос 4-р сард Япон улсад зохион явуулсан 10 дах усанд сэлэлтийн шүүгчийн семинарт 2 дасгалжуулагч оролцсон, 5-р сард Сингапур улсад зохион явуулсан усанд сэлэлтийн багш нар 2 дах түвшний сургалтанд 7 багш амжилттай суралцсан

1991 онд спортын зэрэг цолын комисст 25м усан бассейны зэрэг цолоор тамирчдын амжилтыг үнэлж байсан, тамирчдын ур чадвар дээшлэж гадаадын уралдаан тэмцээнд 50м усан бассейнд уралддаг зэргээс хамааран багш, дасгалжуулагчдын зөвлөлөр хэлэлцэж зэрэг цолыг 25м усан бассейны зэрэг цолыг шинэчилж, 50м усан бассейны зэрэг цолыг шинээр зохион Биеийн тамир спортын газрын зэрэг цолын комиссоор оруулан баталуулсан.





Гадаад харилцаа

Гадаад харилцаандаа сүүлийн жилүүдэд маш их анхаарал тавин ажилласан.

Олон улсын усан сэлэлтийн холбооны хуралд оролцсон.

3 дах насны ангилалтай Сингапур улсын аварга шалгаруулах тэмцээнд Монголын усан спорт клубын баг тамирчид амжилттай оролцсон.

Олимпийн хөгжлийн хөтөлбөрөөр, МҮОХ-ны шугамаар усанд сэлэлтийн дасгалжуулагчдын сургалтыг Улаанбаатар хотод 9 хоног зохион явуулсан.

Сингапур улсад олон улсын усан спортын холбооны дасгалжуулагчийн 2 дах түвшиний сургалтанд 7 дасгалжуулагч хамрагдсан.

Дэлхийн аварга, олимпийн наадамд тамирчидаа амжилттай оролцуулсан.

Якут улсад зохиогдсон залуучуудын олон улсын наадамд эрэгтэй, эмэгтэй тамирчин, дасгалжуулагчын хамт оролцсон.

Хамтын ажиллагаа

1. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2012 оны 03-р сарын 4-5, УССТөвтэй хамтран зохион байгуулсан.

2. Насанд хүрэгчдийн улсын аврага шалгаруулах тэмцээн 2012 оны 03-р сарын 24-25, Хангарьд клубтэй хамтран зохион байгуулсан.

3. "Энгүй тал" цомын төлөөх тэмцээн 2012 оны 06-р сарын 1-3 -ны хооронд Хангарьд клубтэй хамтран зохион байгуулсан.

4. Задгай усанд сэлэлтийн анхдугаар улсын аварга шалгаруулах тэмцээн 2012 оны 07 сарын 07 өдөр Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн цагаан нуурт амжилттай зохион байгуулсан.



Санхүүжилт

Эрдэнэт үйлдвэр ХХК болон Дэд ерөнхийлөгч Д.Баясгалан нараас 30'000'000 төгрөг, Тэргүүлэгч Г.Гансүх - 2'000'000 төгрөг, Тэргүүлэгч гишүүн Ж.Од - 2'000'000 төгрөг, Энгүй тал ХХК - 11'000'000 төгрөг, БТСГазар- 21'500'000 төгрөг, эцэг, эх болон бусдаас 64'547'080 төгрөг зэрэг санхүүжилтаар үйл ажиллагаа явууллаа.

1. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аваргад - 4'035'000 төгрөг
2. Насанд хүрэгчдийн улсын аврагад - 21'500'000 төгрөг
3. "Энгүй тал" цомын төлөөх тэмцээнд - 11'000'000 төгрөг
4. Задгай усанд сэлэлтийн анхдугаар улсын аваргад - 5'000'000 төгрөг
5. FINA шүүгчийн сургалтанд -3'500'000 төгрөг
6. Сингапурын аварга шалгаруулах тэмцээнд -18'750'000 төгрөг
7. FINA дасгалжуулагчдын сургалтанд -16'478'000 төгрөг
8. FINA ахмадын дэлхийн аваргад - 10'000'000 төгрөг
9. Олимпийн наадамд - 1'500'000 төгрөг
10. FINA дэлхийн цомын тэмцээнд - 9'072'000 төгрөг
11. Азийн аварга шалгаруулах тэмцээнд - 30'217'080 төгрөг

Шагнал урамшуулал

МҮОХорооны шагнал

Олимпийн алдар одонгоор

- Д.Бат-Эрдэнэ
- Д.Баяраа
- С.Саранчимэг
- Ж.Туул
- Г.Гансүх

МҮОХорооны Алтан очир одонгоор

- С.Энхтайван



Хэвлэл мэдээлэл

- Улсын аварга шалгаруулах тэмцээнийг ШУУД телевизтэй хамтран нэвтрүүлэх
- Олимпийг шууд нэвтрүүлэх
- Бусад тэмцээнүүдийг

Сургалт дасгалжуулалт

- Дэлхийн усанд сэлэлтийн шүүгчдийн семинар Япон улсад
- FINA-гийн усанд сэлэлтийн дасгалжуулагчын сургалт Сингапур улсад
- Олон улсын олимпийн хорооны эв санааны нэгдлийн усан сэлэлтийн сургалт Улаанбаатар хотод





Цол зэрэг

50м усан бассейны нормитов шинээр зэрэг цолын комисст олон улсын стандартын дагуу Монгол улсын усан сэлэлтийн зэрэг цолыг шинэчлэн гарган батлуулсан.

Усан спортын цол зэргийн болзол хангасан материалыг Монгол улсын цол зэргийн комисст улирал бүр шалган өгч нийт усан спортын олон улсын хэмжээний мастер-1, спортын мастер-3, спортын дэд мастерийн-6 болсон байна.

Олон улсын хэмжээний мастерийн болзол хангасан тамирчин:

1. Б.Дөлгөөн /Хангарьд/, 50м далайн гахай /00:26.10/

Спортын мастерийн болзол хангасан тамирчид:

1. М.Болдбаатар /Хангарьд/, 100м мэлхий сэлэлт /01:07.94/
2. Э.Дэмүүл /Хангарьд/, 100м араар даллах сэлэлт /01:02.86/
3. Г.Занданбал /Хангарьд/, 200м холимог сэлэлт /02:14.42/

Дэд мастерийн болзол хангасан тамирчид:

1. А.Номин /Хангарьд/, Араар даллах сэлэлт 100м /01:14.96/,
2. Б.Мөнхбаярт /УССТ/, Өврөөр даллах сэлэлт 100м /00:58.03/
3. Н.Тэмүүлэн /Mcs-Vista/, Өврөөр даллах сэлэлт 100м /00:58.76/,
4. Э.Бямбасүрэн /Хангарьд/, Өврөөр даллах сэлэлт 100м /00:58.46/
5. Д.Золжаргал /УССТ/, Дельфин сэлэлт 100м /01:10.11/,
6. Д.Дашдаваа /Хангарьд/, Өврөөр даллах сэлэлт 100м /00:58.98/





Дасгалжуулагчийн сургалт






Шинэ жил 2012

Шилдэг эрэгтэй тамирчин - Б.Дөлгөөн
 Шилдэг эмэгтэй тамирчин - А.Номин
 Шилдэг дасгалжуулагч - С.Алтантуяа







2013 оны үйл ажиллагааны тайлан

Бүлэг 5



Ерөнхий мэдээлэл

2013 онд багш дасгалжуулагчдын зөвлөлийн хурлыг сар бүр зохион байгуулж, 2013 онд зохион явагдах уралдаан тэмцээн болон бусад арга хэмжээг тэргүүлэгчдийн хурлаар оруулан батлуулсан.

Соёл спорт аялал жуулчлалын яамнаас спортын холбоодын өмнөх жилийн хийсэн тайлангаар шалгаруулдаг шалгаруулалтанд шилдэг 15-д орж үйл ажиллагааны мөнгөн шагналаар шагнуулан, гэрээ байгуулж, хамтран ажилласан.

FINA-гаас зохион явуулсан олон улсын чуулганд оролцсон. Сингапур улсад 14 хоногийн хамтарсан бэлтгэлд Эрдэнэт болон Улаанбаатар хотын 20 гаруй хүүхэд амжилттай оролцсон.

Тэмцээн уралдаан цаг хугацаандаа болж 2 тамирчин спортын дэд мастерын болзол хангасан. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран газар дээрээс нь шууд дамжуулан Монголын ард түмэнд усан спортыг сурталчилан тус тэмцээнд оролцсон тамирчдын сэлэлтийг олон түмний хүртээл болгосон.


Өгий нуурт задгай усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээний эрэгтэй 5 км, эмэгтэй 3 км-н зайд 30 гаруй тамирчид хүч чадлаа сорин уралдсан.

Холбооны нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээнийг анх удаа 3 өдрөөр 8 наснаас дээш 4 насны ангилалд олон төрлөөр зохион явуулсан мөн анх удаа тэмцээнийг дээд насанд урьдчилсан болон финалын сэлэлтийг зохион явуулсан.

Монгол улсад мөрдөгдөх усан бассейны стандарт боловсруулан соёл спорт аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.

Хамтын ажиллагаа

- 1.Өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2013 оны 02 сарын 23-24, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран зохион байгуулсан.
- 2.Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2013 оны 03-р сарын 23-24, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион байгуулсан.
- 3."Энгүй тал" цомын төлөөх тэмцээнийг 2013 оны 05-р сарын 17-18, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион явуулсан
- 4.Задгай усанд сэлэлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2013 оны 07 сарын 24 өдөр.
- 5.Сингапур улсын усан спортын клубтэй хамтарсан бэлтгэл хийсэн.
- 7.TB5 телевиз, МҮОНТ-тэй гэрээ байгуулан уралдаан тэмцээнийг шууд нэвтрүүлсэн.
- 8.Холбооны фейсбүк хуудсаар мэдээлэл хурдан шуурхай олон нийтэд хүргэсэн.
- 9.Холбооны сэтгүүл гарган олны хүртээл болгосон.
10. АПУ ХХК-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.
11. Номин констракшин ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.



Гадаад харилцаа

МУССХолбооны 2013 оны төлөвлөгөөний дагуу олон улс, дэлхийн уралдаан тэмцээнүүдэд оролцох тамирчид болон албаны хүмүүсийн визийн материалыг холбогдох элчин сайдын яаманд бүрдүүлж 100 хувь виз авсан болно.

Олон улсын усан сэлэлтийн холбооны хуралд энэ жил 2 удаа, дэлхийн аваргад 4 тамирчин 3 албаны хүн 2 телевизийн суравжлагч, оюутаны их наадамд 6 тамирчин, 2 албаны хүн, Азийн тулааны спортын наадамд 8 тамирчин, 5 албаны хүн, Зүүн азийн наадамд 14 тамирчин, 3 албаны хүн амжилттай оролцсон.

Анх удаа 20 гаруй тамирчин, 3 дасгалжуулагчийн хамт Сингапур улсын APCS клубтэй 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийсэн.



Санхүүжилт

1. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аваргад 11.188.000 төгрөг
2. Насанд хүрэгчдийн улсын аврагад 8.848.000 төгрөг
3. "Энгүй тал" цомын төлөөх тэмцээнд 16.013.600 төгрөг
4. Задгай усанд сэлэлтийн анхдугаар улсын аваргад 2.925.000 төгрөг
5. Сингапур улсын усан спортын клубтэй хамтрсан бэлтгэл хийхэд 21.470.000 төгрөг,
6209 ам.доллар
6. Азийн тулааны болон тапхимын наадамд 7.150.000 тогрог, 3.850 ам.доллар
7. Оюутаны их наадамд 5.500. 000 төгрөг, 1.750 евро
8. Дэлхийн аваргад 12.750.000 төгрөг, 14.700 ам.доллар
9. Зүүн азийн аваргад 9.350.000 төгрөг, 5.950 ам.доллар
10. Холбооны нэрэмжит тэмцээн 8.500,000 төгрөг

Сургалт дасгалжуулагч

- Сингапур улсад 3 дасгалжуулагч 14 хоногийн сургалтанд хамрагдсан.



Хэвлэл мэдээлэл

- Өвсөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг ТВ5 телевизтэй хамтран нэвтрүүлсэн
- Анх удаа Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг Үндэсний телевизээр шууд нэвтрүүлсэн
- Бусад тэмцээнүүдийг телевиз олон интернетийн орчинд олон нийтэд хүртээл болгосон
- Холбооны нэрэмжит сэтгүүл эрхлэн гаргасан
- Үндэсний олон нийтийн радио телевизтэй гэрээ байгуулсан

Цол зэрэг

Спортын мастер

1. Ц.Насан - АНУ-ын Техас мужийн усан спортын клуб

Дэд мастериин болзол хангасан тамирчид:

1. Б.Ариунзул – Монголын Усан спорт клуб
2. М.Дэлгэрхүү – Хангарьд клуб

Шагнал урамшуулал

Монголын үндэсний олимпийн хорооны дээд одон “Олимпийн алдар”

1. Х.Хүрэлхүү
2. С.Саранчимэг
3. У.Болдбаатар

МУССХ-ны дээд одон “Усан спортын алдар”

1. Д.Баясгалан - Дэд ерөнхийлөгч
2. Р.Бадрах - Тэргүүлэгч гишүүн
3. А.Тамир - Спортын мастер, Олимпийн наадамд 2 удаа оролцсон



2013 он Дээвэртэй спортын наадам Солонгос, Инчон хот



2013 он Оюутны их наадам
Орос, Казан хот



2013 он Дэлхийн аварга
Испани, Барселона хот



2013 он Зүүн өмнөд Азийн аварга Хятад, Тяньжин хот






Шинэ жил 2013

Шилдэг эрэгтэй тамирчин - Г.Занданбал

Шилдэг эмэгтэй тамирчин - Б.Ариунзул

Шилдэг дасгалжуулагч - А.Тамир







2014 оны үйл ажиллагааны тайлан

Бүлэг 6



Ерөнхий мэдээлэл

2014 онд хийх ажлын талаараа багш, дасгалжуулагчдын зөвлөлд танилцуулаж графикийн дагуу бүх ажлыг 100% гүйцэтгэлээр амжилттай зохион байгуулсан.

Соёл спорт аялал жуулчлалын яамнаас спортын холбоодыг өмнөх жилийн хийсэн тайлангаар 4-р байранд орж улсын аварга шалгаруулах тэмцээн, үйл ажиллагааны мөнгөн шагналаар шагнуулан гэрээ байгуулж хамтран ажилласан.

Азийн олимпийн зөвлөлөөс зохион байгуулсан Азийн усанд сэлэлтийн холбооноос Азийн орнуудын 1 эрэгтэй, 1 эмэгтэй, 1 дасгалжуулагчдын хамт 14 хоногийн сургалтанд хамрагдсан. Тус сургалтын үеэр Катар улсын усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээн зохиогдож манайхаас оролцсон 2 тамирчин Тажикстан, Туркменстан улсын тамирчидтай хамт буухиа сэлэлтэнд оролцож 1 алт, 1 мөнгөн медаль хүртсэн.

Сингапур улсын аварга шалгаруулах тэмцээнд Хангарьд клубын тамирчин ОУХМ Б.Дөлгөөн 50м далайн гахай сэлэлтээр Монгол улсын рекордыг шинэчлэн тогтоож, Сингапур улсын аваргаас 3-р байрт орж хүрэл медалиар энгэрээ мялаасан.

Соёл спорт аялал жуулчлалын яамнаас бичиг ирүүлэн Герман улсад усанд сэлэлтийн 6 сарын сургалтанд багш, дасгалжуулагч хамруулахад манайхаас 3 дасгалжуулагч материалаа өгч СС клубын дасгалжуулагч С.Саранчимэг тэнцэн тус сургалтанд суралцаж ирсэн.

Сингапур улсад 6 тамирчныг Сингапурын шигшээ багтай хамтарсан бэлтгэлд хамаруулсан.

Азийн наадамд оролцох баг тамирчдыг улсын аварга шалгаруулах тэмцээнээс сонгон шалгаруулан эцэг, эх, клубууд, спонсор байгууллагатай хамтран “БИ АВАРГА” уриан дор 2014 оны 8-р сарын 1 нээс 9-р сарын 17-г хүртэл цугларалтанд гарган амжилттай оролцуулсан.

Энэ жил тэмцээн уралдаан цаг хугацаандаа болж 2 тамирчин спортын мастер, 2 тамирчин спортын дэд мастериин болзол хангасан.

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн Катарын Доха хотод болж манайхаас ОУХМ Б.Дөлгөөн 2 зай төрөлд Монгол улсын рекорд, ОУХМ Г.Занданбал 2 зай төрөлд Монгол улсын рекорд, Спортын дэд мастер Ц.Мөнгөнсор 1 зай төрөлд Монгол улсын рекордыг шинэчлэн тогтоосон.

Хамтын ажиллагаа

1. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 03-р сарын 28-30, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион байгуулсан
2. Насанд хүрэгчдийн улсын аврага шалгаруулах тэмцээнийг 04-р сарын 19-20, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион байгуулсан
3. "Энгүй тал" цомын төлөөх тэмцээнийг 07-р сарын 4-6, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион явуулсан
4. "МУССХ"-ны нэрэмжит тэмцээн 11-р сарын 20-22, Эрдэнэт үйлдвэрийн Спорт цогцолбортой хамтран амжилттай зохион явуулсан
5. Солонгос улсын усан спортын холбоотой хамтран 8-р сарын 24 ноос 9-р сарын 17-ныг хүртэл хамтрсан бэлтгэл хийсэн
6. Сингапур улсын усан спортын клубтэй 6-р сарын 1-нээс 8-р сарын 1 хүртэл хамтарсан бэлтгэл хийсэн .
7. Холбооны фейсбүүк хуудсаар мэдээлэл хурдан шуурхай олон нийтэд хүргэсэн
8. Сод монгол ХХК-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан
9. Номин констракшн ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
10. Өрмөн-Уул ХХК хамтран ажилласан.

Гадаад харилцаа

1. Солонгос улсын усан спортын холбоотой хамтран 30 хоногийн хамтарсан бэлтгэл хийсэн.
2. Сингапурт 2 сарын хугацаатай хамтарсан бэлтгэл хийсэн.
3. Азийн зөвлөлөөс зохион явуулсан зуны сургалтанд оролцсон.
4. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон.
5. Азийн наадамд өргөн бүрэлдэхүүнээр оролцсон.





Санхүүжилт

1. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аваргад 7'515'348 төгрөг
2. Насанд хүрэгчдийн улсын аврагад төгрөг 7'226'000 төгрөг
3. "Энгүй тал" цомын төлөөх тэмцээнд 15'234'000 төгрөг
4. Холбооны нэрэмжит тэмцээнд 2'749'500 төгрөг
5. Сингапур улсын усан спортын клубтэй хамтрсан бэлтгэл хийхэд
6. Азийн наадамд 41'642'000 төгрөг, 5000 ам.доллар
7. Азийн зуны сургалт
8. Дэлхийн аваргад 12'000'000 төгрөг, 5880 ам.доллар
9. Мастерсийн улсын аваргад 1'300'000 төгрөг

Хэвлэл мэдээлэл

